



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



Сүхбаатар аймгийн нийгэм,
эдийн засгийн байдал
2017/9

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2017/9



sukhbaatar.nso.mn

www.1212.mn



Monstat



ezStat

Статистикийн хэрэглэгч та бүхэн манай хэвлэмэл бүтээгдэхүүн болон тоо мэдээллүүдийг **МОНСТАТ**, **ezStat** аппликейшнуудээр дамжуулан Apple-ын iPhone, iPad төхөөрөмжтэй бол **App store**-с, андройд үйлдлийн системийн төхөөрөмжтэй бол **Google play**-с татан авч, суулгаж ашиглах боломжтой.

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХААНААС, ХЭРХЭН АВАХ ВЭ?

 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан

www.sukhbaatar.nso.mn

Сүхбаатар аймгийн статистик
хэлтсийн вэб хуудас



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах **ezStat** аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
Монстат аппликейшн



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү 

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)

СҮХБААТАР АЙМАГ



[www.facebook.com/
statistic](http://www.facebook.com/statistic)



Утсаар:



Лавлах утас

1900-1212

Сүхбаатар аймаг

7051-8203



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**9 сар
2017**

Баруун-Урт сум



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	3
Аргачлалын тайлбар	4-5
Товч танилцуулга	6-18
Үндсэн үзүүлэлтүүд	19

I. Нийгмийн үзүүлэлт

I.1 Хөдөлмөр	20-22
I.2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж	23-24
I.3 Боловсрол	25
I.4 Эрүүл мэнд	26-27
I.5 Соёл, урлаг	28
I.5 Газар өмчлөл	29
I.6 Гэмт хэрэг	30-31

II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Мөнгө, банк, даатгал	32-33
II.2. Төрийн санхүү	33-35
II.3 Төсөл хөтөлбөр	36
II.4 Үнэ	37-38
II.5 Хөдөө аж ахуй	39-43
II.6 Аж үйлдвэр	44-46
II.7 Тээвэр холбоо	47
II.8 Барилга	47



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэлгээ:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-VI зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

...	Мэдээлэл байхгүй	x	Бүтцийн өөрчлөлт
0.0	Маш бага тоо	+, -	Зөрүү
-	Гүйцэтгэл байхгүй	*	Дахин

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 17-16 нь 2017 оны үзүүлэлтийн тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. "Төл" нь төлөвлөгөөг, "Гүйц" нь гүйцэтгэл.

VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Тэтгэвэр, тэтгэмж:** Уг мэдээг нийгмийн даатгал, халамж үйлчилгээний хэлтсүүд нь гарган нэгтгэж ирүүлдэг.
- **Эрүүл мэнд:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Соёл, урлаг:** Соёл, урлагийн үйл ажиллагааг эрхэлдэг газрууд нь мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.
- **Газар өмчлөгч:** Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь сумдаас мэдээллийг авч нэгтгэн ирүүлсний дагуу мэдээллийг хүргэдэг.
- **Гэмт хэрэг:** Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатайгаар, болгоомжгүйгээ салах хэргийг нэгтгэн оруулсан.
- Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.



- Нийгмийн Аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
- 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Мөнгө, банк, даатгал:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг. Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд үндсэн үйл ажиллагааны мэдээллийг гаргаж ирүүлдэг.
- **Төсөл:** Засгийн газрын зарим гол төслүүд болон сангуудын хөрөнгийн зээл олголт, үйл ажиллагааны мэдээллийг холбогдох хэлтэс, агентлагууд гаргаж ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ гэдэг нь** өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдол, тариалсан талбайн мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.
- **Тээвэр, Холбоо:** Уг үйл ажиллагааг эрхэлдэг ААН-нэгжүүд болон сумдын тамгын газрууд мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.



Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2017 оны эхний 9 сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт



I.1. Хүн ам

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2017 оны эхний 9 сард 898 хүүхэд шинээр мэндэлж, 245 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 653 болж урьд оны мөн үеийнхээс 8.0 хувиар буюу 57-оор буурлаа. 1000 хүнд ногдох төрөлт 15.1, нас баралт 4.1 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 1.6 пункт, нас баралт 0.4 пунктээр тус тус буурчээ.

Зураг.I.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 9 сард




I.2 Хөдөлмөр

Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2017 оны 9 дүгээр сарын эцэст 1071 болсон, үүний 547 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 807 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.0 хувь буюу 109 хүнээр буурч, 2016 оны 12 дугаар сарын эцсээс 6.0 хувь буюу 46 хүнээр өссөн байна.

Эхний 9 дүгээр сарын байдлаар хөдөлмөр халамж үйлчилгээний газарт 2927 иргэн шинээр бүртгүүлсний 637 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг.I.2.1 Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд





Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 64.0 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.4 хувь нь магистр, доктор, 30.1 хувь нь дээд, 3.0 хувь нь тусгай дунд, 12.6 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 35.8 хувь нь бүрэн дунд, 11.6 хувь нь суурь, 5.5 хувь нь бага боловсролтой, 1.0 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Зураг.1.2.2 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр,
9 дүгээр сарын байдлаар



Эхний 9 дүгээр сарын байдлаар 337 шинэ ажлын байр бий болсны дотор уул уурхай, олборлох салбар 92, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 90, хөдөө аж ахуйн салбар 83 байгаа нь хамгийн өндөр үзүүлэлтэй байна.



1.3 Нийгмийн даатгал, халамж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 9.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.6 тэрбум төгрөг буюу 6.6 хувиар өсчээ.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 531.5 сая төгрөгний шимтгэл төлсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 54.6 сая төгрөг буюу 11.4 хувиар өссөн байна.

Нийт 7.5 мянган иргэнд 18.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосноос 5.6 мянган өндөр настанд 13.5 тэрбум төгрөг, 1.2 мянган тахир дутуу иргэнд 2.5 тэрбум төгрөг, 417 тэжээгчээ алдсан иргэнд 0.9 тэрбум, 297 иргэнд цэргийн тэтгэвэр 1.4 тэрбум төгрөгийг тус тус бүрэн олгожээ. Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.3 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн сангаас 3.0 тэрбум төгрөгийг 11.5 мянган иргэнд, улсын төсвөөс 1.6 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 11.6 мянган иргэнд тус тус олгожээ.



I.4 Боловсрол, шинжлэх ухаан


Ерөнхий боловсролын сургууль: 9-р сарын урьдчилсан байдлаар 2017-2018 оны хичээлийн жилд 11.3 мянган суралцагчид байгаагийн 50.2 хувь болох 5.7 мянга нь эмэгтэй сурагчид байна. Өмнөх оны мөн үеэс сурагчдын тоо 4.8 хувь буюу 520 хүүхдээр өсчээ. Нийт сурагчдын 48.9 хувь болох 6.0 мянга нь 1-5-р ангид, 31.9 хувь болох 3.6 мянга нь 6-9-р ангид, 14.6 хувь болох 1.6 мянга нь 10-12-р ангид суралцаж байна.

Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.5 мянган сурагч элсэн орсны 48.6 хувь болох 722 нь эмэгтэй сурагч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.2 хувь буюу 232 сурагчаар өссөн байна. Мөн 12-р ангид 0.7 мянган сурагч байгаагийн 59.0 хувь буюу 421 нь эмэгтэй сурагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.0 хувь буюу 23 сурагчаар өсчээ.

Энэ хичээлийн жилд 395 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 29 сурагч ногдож байна. 1 багшид ногдох сурагчийн тоо 20 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй адил түвшинд байна. Нийт ажиллагсдын 50.0 хувь болох 567 нь үндсэн багш байна. Үүний 79.3 хувь болох 450 нь эмэгтэй багш нар байна. Өмнөх оны мөн үеэс багш нарын тоо 3.3 хувиар өссөн байна.

Дотуур байранд 959 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар буурчээ.


Зураг I.4.1 Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо



Сургуулийн өмнөх боловсрол: 2017-2018 оны хичээлийн жилд 175 бүлэгт 5.3 мянган хүүхэд хүмүүжиж байгаагийн 49.6 хувь буюу 2.6 мянга нь эмэгтэй хүүхэд байна. Өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар буюу 579 хүүхдээр өсчээ. Нийт хүмүүжиж байгаа хүүхдийн 4.2 мянга болох 79.4 хувь нь үндсэн цэцэрлэгт, 1.1 мянга болох 20.6 хувь нь хувилбарт сургалтанд хамрагджээ Нийт ажиллагсдын 28.8 хувь болох 172 нь үндсэн багш байна.




Зураг I.4.2 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2017-2018 оны хичээлийн жилд 13 мэргэжлээр 299 суралцагчид суралцаж байгаагийн 43.8 хувь болох 131 нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс нийт суралцагчдын тоо 22.3 хувь болох 86 суралцагчаар буурсан байна.

Нийт суралцагчдын 86.6 хувь болох 259 нь мэргэжлийн боловсрол эзэмшихээр сурч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 25.8 хувь буюу 90 суралцагчаар буурсан байна. Мэргэжил олгох 1 жилийн сургалтанд 40 хүн сурч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 11.1 хувь буюу 4 хүнээр буурсан байна. Нийт суралцагчдын 24.1 хувь нь барилгын засал чимэглэгч, 14.0 хувь нь барилгын цахилгаанчин, 10.0 хувь нь гоо засалч, 8.0 хувь нь авто машины засварчин, 7.7 хувь нь бетон арматурчин мэргэжлээр сурч байгаа нь олонх байна.

Зураг I.4.3 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоо




**I.5 Эрүүл мэнд**

Аймгийн хэмжээнд эхний 9 сарын байдлаар 175.8 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар буурч, 9.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны түвшинд байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 54.6 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 20.5 хувиар буурсан байна.

Түргэн тусламжийн дуудлага 13.1 мянган удаа гарсны 3.7 мянга буюу 28.2 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 1.6 хувиар, алсын дуудлага 2.8 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээнд 900 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 898 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 64 буюу 6.6 хувиар, хүүхдийн тоо 75 буюу 7.3 хувиар тус тус буурчээ.

Зураг I.5 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо




Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо эхний 9 сард 962 болж, өмнөх оны мөн үеэс 153 хүн буюу 13.7 хувиар буурсан байна.


**I.6 Соёл, урлаг:**

Хөгжимт жүжгийн театр: 6.2 мянган үзэгчдэд 13 тоглолтоор үйлчилж 8.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс үзэгчдын тоо 29.2 хувь, тоглолтын тоо 44.4 хувиар тус тус өсч харин орлого нь 53.4 хувиар буурчээ.

Зураг I.6.1 Нийт тоглолтын тоо




Зураг I.6.2 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн






Музей: 2.1 мянган үзмэрээр 1.7 мянган хүнд үйлчилж 1.3 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзэгчдийн тоо 88.9, орлогын тоо 44.3 хувиар тус тус өсч харин үзмэрийн тоо адил түвшинд байна.

Зураг I.6.3 Нийт үзмэрийн тоо




Зураг I.6.4 Нийт үзэгчдийн тоо




Номын сан: Нийт 46.4 мянган номоор 15.4 мянган уншигчдад үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс уншигчдын тоо 24.9 хувиар буурч номын тоо адил түвшинд байна.

Зураг I.6.5 Нийт номын тоо



Зураг I.6.6 Нийт уншигчдын тоо, мян.хүн




I.7 Байгаль орчин:


1.7.1 Газар өмчлөл: Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 9.8 мянган иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 9.3 мянган иргэнд 834.3 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байна. Өмнөх оны мөн үеэс өргөдөл гаргасан иргэдийн тоо 0.5 мянга буюу 6.0 хувиар өсчээ. Шинээр 293 иргэн өргөдөл гаргаснаас Засаг даргын шийдвэр гарсан 144 иргэнд 12.64 га газрыг тус тус олгоод байна.



Зураг I.7.1.1 Газар өмчлөх өргөдөл гаргасан иргэдийн тоо



Зураг I.7.1.2 Засаг даргын шийдвэр гарсан иргэдийн тоо



1.7.2 Ус цаг уур: Ус цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр: 2017-2018 оны хүйтний улирлын урьдчилсан төлөв: Агаарын температур: 11 дүгээр сар, 2018 оны хоёр, гурав дугаар саруудад уур амьсгалын дунджаас дулаан харин 10, 12, 1 дүгээр саруудад дунджийн орчим байхаар байна. Хур тунадас: 10, 11 дүгээр саруудад нийт нутгаар ахиу мөн 12, 3 дугаар саруудад нутгийн зүүн хэсгээр ахиу харин 2 дугаар сард нутгийн баруун хэсгээр дунджаас бага 1 дүгээр сард нийт нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна. Хүйтний улирлын төлөвөөр ихэнх саруудад хур тунадас ахиу орохоор байгаа тул зуншлага муу гантай байсан нутгуудад мал өвөлжилт, хаваржилт хүндрэх нөхцөл бүрдэх төлөвтэй байгааг анхаарч хадлан тэжээл бэлтгэх, татаж байршуулах, отор нүүдэл хийх ажлыг цас орж, цасан бүрхүүл тогтох, хүйтрэхээс өмнө оновчтой зохион байгуулах шаардлагатай байна.

Аравдугаар сард. Уур амьсгалын дунджаар агаарын сарын дундаж температур нийт нутгаар 1-4 градус дулаан байдаг.

Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар дунджийн орчим байх төлөвтэй (1 дүгээр зураг).

1-р зураг. 10-р сарын агаарын температурын урьдчилсан төлөв



2-р зураг. 10-р сард орох хур тунадасны урьдчилсан төлөв





Хур тунадас нутгийн баруун хэсгээр 1-5 мм, бусад нутгаар 6-11 мм ордог. Урьдчилсан мэдээгээр нийт нутгаар уур амьсгалын дунджаас ахиу хур тунадас орох төлөвтэй (2 дугаар зураг).

Арваннэгдүгээр сард. Уур амьсгалын дунджаар агаарын сарын дундаж температур нийт нутгаар 9-14 градус хүйтэн байдаг. Нутгийн зүүн өмнөд хэсгээр 5-11 мм, бусад нутгаар 1-4 мм цас ордог.

Энэ сард агаарын дундаж температур нутгийн баруун хойд хэсгээр дунджийн орчим, бусад ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас 0.5-1.5 градусаар дулаан байх төлөвтэй(3 дугаар зураг).

3-р зураг. 11-р сарын агаарын температурын урьдчилсан төлөв.



4-р зураг. 11-р сард орох хур тунадасны урьдчилсан төлөв.



Ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас ахиу, Эрдэнэцагаан сумын нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй (4 дүгээр зураг).



I.8 Гэмт хэрэг

Эхний 3-р улирлын байдлаар нийт 245 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 24 хүн нас барж, 118 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 6-аар буурчээ.


Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 381.5 сая төгрөгийн хохирол учирсны 57.9 хувийг нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэрэгт 194 хүн холбогдон сэжиглэгдсэний 32.0 хувь нь согтуугаар, 10.0 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлджээ.

Нийт 349 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 39 хүн буюу 10.0 хувиар буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 56 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 42.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 31.0 пунктээр буурсан байна.



Зураг I.8 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, банк, даатгал

Монгол банкны мэдээгээр ХААН, Төрийн, Хас, Голомт, Капитал банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 115.6 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 16.2 тэрбум төгрөг буюу 16.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 13.8 тэрбум төгрөг буюу 13.6 хувиар тус тус өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 44.7 тэрбум төгрөг болж оны эхнээс 2.4 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум төгрөгөөр өсчээ.

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл эхний 9 сарын эцэст 2.7 тэрбум болж өмнөх сараас 0.2 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум төгрөгөөр өссөн. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.3 хувийг эзэлж байна.

Зураг II.1.1 Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл сарын эцэст, тэрбум төг




Даатгал: Даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 376.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар буурсан байна.

Нөхөн төлбөр 1304 хүнд 34.4 сая төгрөг олгосны дотор авто тээврийн хэрэгсэлд 3.4 сая, жолоочийн хариуцлагад 20.1, иргэдийн эд хөрөнгөнд 0.9 сая,



гэнэтийн осолд 5.1 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 4.1 сая, хүүхдийн гэнэтийн осолд 0.8 сая төгрөгийг тус тус олгожээ.

Зураг II.1.2 Даатгалын төрлөөр




II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого эхний 9 сард 32.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.7 тэрбум төгрөг буюу 14.8 хувиар буурч, төсвийн зарлага санхүүжилт 35.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.2 тэрбум төгрөг буюу 0.4 хувиар өсчээ.

Аймгийн нэгдсэн төсвийн 14.0 хувийг татварын орлого, 7.6 хувийг татварын бус орлого, 0.2 хувийг хөрөнгө борлуулсны орлого, 78.2 хувийг тусламжийн орлого тус тус эзэлж байна.

Зураг.II.2.1 Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг





Орон нутгийн хөгжлийн сангаас 1.2 тэрбум төгрөг, улсын төсвөөс 0.2 тэрбум төгрөг, нийт 1.4 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтыг эхний 3-р улирлын байдлаар хийгээд байна.

II.3 Төсөл хөтөлбөр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас эхний хагас жилд 763.0 сая төгрөгийн санхүүжилтийг 9 төрлийн төсөл хөтөлбөрт олгожээ.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэмжээнд 6 иргэнд 24.0 сая төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хөтөлбөрийн хэмжээнд 4 иргэнд 7.5 сая төгрөг, жижиг зээлийг 23 иргэнд 173.0 сая төгрөг, нийтийг хамарсан ажлын зохион байгуулах хөтөлбөрийн хэмжээнд 125 иргэнд 35.0 сая төгрөг, хүнсний ногоо тариалах хөтөлбөрт 63 иргэнд 22.5 сая төгрөг, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 75 иргэнд 135.0 сая төгрөг, аж ахуй эрхлэх бичил бизнесийг дэмжих хөтөлбөрт 70 иргэнд 105.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 12 иргэнд 36.0 сая төгрөгийн зээл, тус тус олгосон.

Мөн 47 өрхийг малжуулах хөтөлбөрт хамруулан 4094 толгой малыг 225.0 төгрөгөөр авч малтай болгосон.




II.3 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2017 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.4 хувь, жилийн эцсээс 4.2 хувиар тус тус өслөө.

Зураг II.3 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)





Хүснэгт II.3 Хэрэглээний үнийн индекс, 2017 оны 9 дүгээр сар, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2017.IX}{2016.IX}$	$\frac{2017.IX}{2016.XII}$	$\frac{2017.IX}{2017.VIII}$
Ерөнхий индекс	105.4	104.2	100.0
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	109.2	107.1	100.6
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	111.0	103.2	100.0
Хувцас, бөс бараа, гутал	101.0	100.7	99.9
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	98.4	98.6	99.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.5	103.3	99.9
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	109.4	107.8	100.0
Тээвэр	110.9	110.9	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	97.6	99.7	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	101.3	99.4	99.4
Боловсролын үйлчилгээ	100.7	99.5	100.1
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	101.2	100.2	100.0
Бусад бараа, үйлчилгээ	107.6	101.9	99.9

Ерөнхий индекс өмнөх жилийн эцсээс 4.2 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 7.1 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисийн бүлгийн үнэ 3.2 хувь, хувцас бөс барааны бүлгийн үнэ 0.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 3.3 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ 7.8 хувь, тээврийн бүлгийн үнэ 10.9 хувь, , зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 0.2 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 1.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

**II.4 Хөдөө аж ахуй**


Мал төллөлт төл бойжилт. Оны эхний төллөх насны хээлтэгч малын 86.6 хувь буюу 1.2 сая хээлтэгч эхний 9 сарын байдлаар төллөсөн байна. Таван төрлөөр нь авч үзвэл: эм хонь 87.9 хувь, эм ямаа 87.1 хувь, гүү 80.9 хувь, үнээ 80.8 хувь, ингэ 42.4 хувь тус тус төллөжээ.

Гарсан төлийн 99.4 хувь болох 1.2 сая төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.2 сая буюу 2.0 пунктээр өссөн байна.

Төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл: Унага, хурга 99.5 хувь, тугал 99.4 хувь, ишиг 99.2 хувь, ботго 98.9 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс бүх төрөлдөө 0.9-2.8 пунктээр өссөн байна.



Зураг-II.4.1 Төллөсөн хээлтэгчийн тоо, сумаар, мян.толгой, 2017 оны эхний 7 сарын байдлаар



Зураг-II.4.2 Бойжуулсан төлийн тоо, сумдаар, мян.толгой, 2017 оны эхний 7 сарын байдлаар



Малын онд оролт: Том малын зүй бус хорогдол эхний 9 сард 11.5 мянган толгой болж, өмнөх оны мөн үеэс 173.1 мянган толгойгоор буюу 93.7 хувиар буурсан байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 16, адуу 0.3 мянга, үхэр 4.0 мянга, хонь 4.3 мянга, ямаа 2.9 мянган толгой байна.

Малын нийт хорогдлын 38.0 хувийг хонь эзэлж байна. Аймгийн хэмжээнд хорогдсон бүх мал нь оны эхний малын 0.4 хувийг эзэлж байна.


Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон мал 37.0 хувь буюу 4.2 мянган толгой болж, өмнөх оны мөн үеэс 6.5 дахин өсчээ.

Ургац хураалт, хадлан бэлтгэл: Ургац хураалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд эхний 9 дүгээр сард 1.5 мянган тн үр тариа, 496.9 тн төмс, 222.6 тн хүнсний ногоо, 370 тн техникийн ургамал бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс үр тариа 3.5 дахин, төмс 27.0 хувь, хүнсний ногоо 17.6 хувиар тус тус өсчээ.

Эхний 9 сарын байдлаар өвс 3.9 мянган тн, гар тэжээл 74.0 тн, хужир шүү 50.0 тн, дарш 5 тн тус тус бэлтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс өвс 62.9 хувь, гар тэжээл 57.3 хувь, хужир шүү 93.6 хувиар тус тус буурсан байна.



Зураг II.4.3 Хураасан ургац. тн-оор

**II.5 Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 28.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 3.7 тэрбум төгрөг буюу 11.4 хувиар буурчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: уул уурхай, олборлох аж үйлдвэрийнх 22.9 тэрбум төгрөг болж 12.4 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 0.8 тэрбум төгрөг буюу 16.2 хувиар тус тус буурч харин цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 2.2 тэрбум төгрөг буюу 4.9 хувиар өслөө.

Оны үнээр 156.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 46.5 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хүрэн нүүрс, төмрийн хүдрийн баяжмал, цахилгаан, хийжүүлсэн цэвэр ус, рашаан, хэвийн боов, хэрчсэн гурил, цөцгий, дээлнээс бусад монгол хувцас, гутал, дээл, хүрэм, туурга, гэрийн бусад модон тавилга, гал зуух хоолны төмөр эдлэл, гэр ахуйн төмөр эдлэл зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс өссөн байна.

**II.6 Тээвэр, холбоо**

Тээвэр: Авто тээвэр бүхий байгууллагууд эхний 9 сард 105.1 мян.тн ачаа, давхардсан тоогоор 28.0 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 58.8 мян.тн буюу 35.8 хувь, зорчигчдын тоо 28.0 мянган хүн буюу 2.8 хувиар тус тус буурчээ.

Авто тээврийн орлого 5.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.1 тэрбум төгрөг буюу 29.2 хувиар буурчээ.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 433.6 сая төгрөгт хүрсний 78.3 хувь болох 94.2 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Өмнөх оны мөн үеэс холбооны орлого 70.1 сая төгрөг буюу 19.3 хувиар, хүн амаас орох орлого 16.3 хувиар тус тус өсчээ. Телефон цэгийн тоо 502 болж, өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар буурлаа.



Шуудан үйлчилгээний газар нь эхний 9 сарын байдлаар бичиг захидал 4.8 мянга, илгээмж 0.8 мянга, хэвлэл 76.4 мянгыг хүлээн авчээ. Өмнөх оны мөн үеэс бичиг захидал хүлээн авалт 2.0 хувиар буурч, сонин хэвлэл 59.5 хувиар өссөн байна. Бичиг захидал 9.5 мянга, илгээмж 0.2 мянга, сонин хэвлэл 144.2 мянгыг тус тус явуулжээ. Өмнөх оны мөн үеэс бичиг захидал 39.7 хувиар, хэвлэл 5 дахин тус тус өсч, харин илгээмж 60.0 хувиар буурсан үзүүлэлт гарчээ.

Зураг II.6 Холбооны үндсэн үзүүлэлт, оны үнээр сая.төг



II.7 Барилга

Барилгын байгууллагууд эхний 9 сарын байдлаар нийт 6.1 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийжээ. Үүний 1.8 тэрбум төгрөг буюу 29.3 хувь нь аймгийн, 4.4 тэрбум төгрөг буюу 70.7 хувь нь гадны барилгынбайгууллагууд тус тус хийж гүйцэтгэсэн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, эхний 9 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2015	2016	2017	Зөрүү	$\frac{2017}{2016}$ %
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд						
Төрсөн хүүхэд	хүн	1 046	973	898	- 75	92.3
Нялхасын эндэгдэл	хүн	14	23	14	- 9	60.9
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	881	916	807	- 109	88.1
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	597	1 115	962	- 153	86.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	259	251	245	- 6	97.6
Хэрэгт холбогсод	хүн	271	237	194	- 43	81.9
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	104.5	100.7	104.2	3.5	103.5
Иргэдийн хадгаламж	сая.төг	32 050.9	42 235.4	44 669.3	2 433.9	105.8
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	100 297.9	101 733.6	115 569.5	13 835.9	113.6
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	35 081.9	38 394.5	32 728.7	-5 665.8	85.2
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	32 906.3	35 679.3	35 836.0	156.7	100.4
Төлөрсөн хээлтэгч	тол	1069 486	1 005 266	1 183 132	177 866	117.7
-Ингэ	тол	1 468	1 139	1 296	157	113.8
-Гүү	тол	54 197	57 012	68 185	11 173	119.6
-Үнээ	тол	60 596	59 909	66 313	6 404	110.7
-Эм хонь	тол	557 085	538 686	640 164	101 478	118.8
-Эм ямаа	тол	396 140	348 520	407 174	58 654	116.8
Бойжуулсан төл	тол	1063 005	986 085	1 183 619	197 534	120.0
-Ботго	тол	1 445	1 095	1 282	187	117.1
-Унга	тол	53 809	56 193	67 818	11 625	120.7
-Тугал	тол	60 215	58 825	65 931	7 106	112.1
-Хурга	тол	554 879	529 257	640 900	111 643	121.1
-Ишиг	тол	392 657	340 715	407 688	66 973	119.7
Том малын зүй бусын хорогдол	тол	13 093	184 648	11 519	-173 129	6.2
- Тэмээ	тол	66	63	16	- 47	25.4
- Адуу	тол	1 171	8 473	334	-8 139	3.9
- Үхэр	тол	767	15 096	3 984	-11 112	26.4
- Хонь	тол	5 287	69 407	4 334	-65 073	6.2
- Ямаа	тол	5 802	91 609	2 851	-88 758	3.1
Үүнээс: Өвчнөөр хоргдсон мал	тол	306	652	4 219	3 567	6.5*
- Тэмээ	тол	-	-	-	-	-
- Адуу	тол	3	3	-	-	-
- Үхэр	тол	4	4	2 704	2 700	676.0*
- Хонь	тол	640	640	1 431	791	223.6
- Ямаа	тол	5	5	84	79	16.8*
Хураасан ургац, хадлан						
Үүнээс: Үр тариа	тн	1.3	422.0	1 484.5	1 062.5	3.5*
Төмс	тн	581.7	391.3	496.9	105.6	127.0
Хүнсний ногоо	тн	210.1	189.3	222.6	33.3	117.6
Бэлтгэсэн өвс	тн	13 791.0	10 427.0	3 865.0	-6 562.0	37.1
Гар тэжээл	тн	143.0	173.3	74.0	- 99.3	42.7
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	29 035.0	32 662.5	28 948.4	-3 714.1	88.6
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	103 341.0	109 694.3	156 153.2	46 458.9	142.4
Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр	сая.төг	31 993.6	11 276.8	6 161.3	-5 115.5	54.6
Тээврийн орлого	сая.төг	5 739.2	7 180.3	5 134.0	-2 046.3	71.5
Тээсэн ачаа	мян.тн	137.8	163.9	105.1	- 58.8	64.1
Ачаа эргэлт	мян.тн.км	36 277.0	42 605.5	27 157.4	-15 448.1	63.7
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	41.9	28.8	28.0	- 0.8	97.2
Зорчигч эргэлт	мян.хүн.км	23 999.0	15 449.0	14 918.7	- 530.3	96.6
Холбооны орлого	сая.төг	358.9	363.5	433.6	70.1	119.3
Үүнээс: Хүн амын	сая.төг	103.0	81.0	94.2	13.2	116.3

**I.1 ХӨДӨЛМӨР****I.2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сум	2015		2016		2017	2017.IX 2016.IX %
	IX	XII	IX	XII	IX	
Асгат	14	3	21	27	22	104.8
Баяндэлгэр	28	8	43	31	50	116.3
Дарьганга	10	10	24	36	32	133.3
Мөнххаан	12	4	14	17	16	114.3
Наран	12	5	14	14	22	157.1
Онгон	17	12	29	25	9	31.0
Сүхбаатар	18	10	31	21	4	12.9
Түвшинширээ	36	27	28	31	36	128.6
Түмэнцогт	13	10	24	50	33	137.5
Уулбаян	5	1	12	9	73	6.1*
Халзан	10	5	17	15	21	123.5
Эрдэнэцагаан	34	14	59	42	26	44.1
Баруун-Урт	672	323	600	443	463	77.2
Дүн	881	432	916	761	807	88.1

I.2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр							Насны бүлгээр					
			Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Асгат	22	10	-	2	-	7	11	2	-	-	8	11	1	1	1
Баяндэлгэр	50	29	-	7	1	6	17	15	2	2	12	19	12	6	1
Дарьганга	32	20	-	3	-	8	9	12	-	-	9	13	6	4	-
Мөнххаан	16	6	-	6	-	-	9	-	1	-	3	6	5	2	-
Наран	22	8	-	10	2	1	4	4	1	-	7	7	7	-	1
Онгон	9	6	-	7	-	-	1	1	-	-	5	3	1	-	-
Сүхбаатар	4	4	-	3	-	-	1	-	-	-	4	-	-	-	-
Түвшинширээ	36	19	-	10	2	3	11	3	5	2	11	11	9	5	-
Түмэнцогт	33	15	-	11	3	2	12	3	2	-	7	6	11	6	3
Уулбаян	73	35	-	12	2	6	27	12	13	1	15	29	17	10	-
Халзан	21	7	-	6	-	-	10	3	2	-	8	3	5	5	-
Эрдэнэцагаан	26	17	-	10	2	3	8	2	1	-	9	15	1	1	-
Баруун-Урт	463	228	3	156	12	66	169	37	17	3	93	199	109	48	14
Дүн	807	404	3	243	24	102	289	94	44	8	191	322	184	88	20



I.2.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2015		2016		2017	$\frac{2017.I-IX}{2016.I-IX} \%$
	I-IX	I-XII	I-IX	I-XII	I-IX	
Асгат	34	40	53	117	137	258.5
Баяндэлгэр	71	99	100	195	102	102.0
Дарьганга	19	38	72	143	41	56.9
Мөнххаан	51	59	36	52	79	219.4
Наран	41	57	41	94	185	4.5*
Онгон	28	73	72	116	67	93.1
Сүхбаатар	44	59	102	140	123	120.6
Түвшинширээ	60	85	69	116	111	160.9
Түмэнцогт	28	38	63	110	82	130.2
Уулбаян	29	31	31	88	160	5.2*
Халзан	18	47	36	79	67	186.1
Эрдэнэцагаан	107	212	202	286	75	37.1
Баруун-Урт	1 369	1 759	1 813	2 268	1 698	93.7
Дүн	1 899	2 597	2 690	3 804	2 927	108.8


I.2.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2015		2016		2017	$\frac{2017.I-IX}{2016.I-IX} \%$
	I-IX	I-XII	I-IX	I-XII	I-IX	
Асгат	18	19	-	32	82	-
Баяндэлгэр	39	56	22	96	25	113.6
Дарьганга	4	17	5	29	8	160.0
Мөнххаан	33	36	4	8	5	125.0
Наран	26	26	15	46	86	5.7*
Онгон	10	22	2	6	8	4.0*
Сүхбаатар	19	26	28	44	37	132.1
Түвшинширээ	27	38	3	19	19	6.3*
Түмэнцогт	13	13	8	11	6	75.0
Уулбаян	12	12	2	42	-	-
Халзан	8	30	3	33	28	9.3*
Эрдэнэцагаан	43	126	39	86	10	25.6
Баруун-Урт	317	436	225	298	313	139.1
Дүн	569	857	356	750	637	178.9



I.1.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо		Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар									
			ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах үйлдвэр	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	бусад
	2016 I-IX	2017 I-IX										
Асгат	4	26	16	-	6	-	4	-	-	-	-	-
Баяндэлгэр	17	11	9	-	1	-	-	-	1	-	-	-
Дарьганга	16	10	9	1	-	-	-	-	-	-	-	-
Мөнххаан	4	13	7	4	-	-	-	2	-	-	-	-
Наран	14	30	4	-	-	-	3	23	-	-	-	-
Онгон	10	4	4	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	16	9	8	-	-	-	-	-	-	-	-	1
Түвшинширээ	8	12	9	-	1	-	-	-	-	-	2	-
Түмэнцогт	17	1	-	1	-	-	-	-	-	-	-	-
Уулбаян	9	19	-	13	-	-	2	-	-	4	-	-
Халзан	9	5	-	-	-	4	1	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	28	10	9	1	-	-	-	-	-	-	-	-
Баруун-Урт	216	187	8	72	2	-	11	-	-	2	88	4
Дүн	368	337	83	92	10	4	21	25	1	6	90	5



I.2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, сумаар, сая.төг

1.2.2 ТЭТГЭВЭР ОЛГОЛТ, сумаар

~ 27 ~



I.2.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

Үзүүлэлт		2016.I-IX		2017.I-IX	
		Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Халамжийн сан	1 Халамжийн тэтгэвэр	1 575	1359.8	1 302	1457.6
	2 Халамжийн тэтгэмж	1 513	288.7	1 039	341.6
	3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа	11	1.3	19	2.3
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	3	3.6	2	2.4
	Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа	15	18.0	9	10.8
	2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	9	18.0	13	26.0
		8	9.6	1	1.2
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн 10 хүртэлх насны баингын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	127	111.6	151	170.4
	Баингын асаргаа шаардлагатай ахмад настан иргэн	538	56.8	599	90.6
	Баингын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	802	69.8	245	37.9
	3 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 178	442.7	1 095	515.0
	байнгын асаргаа шаардлагатай Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	691	261.8	628	290
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	290	105.4	261	120.0
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	134	51.9	154	76.7
	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	21	8.4	17	9.2
	Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	13	5	12	7.6
	Хүүхэд, төрөл садангүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	29	10.2	23	11.5
	4 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	14	18.8	75	10.7
	Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай				
	5 хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж	3 305	147.9	3 239	241.3
	6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж	297	66.3	368	80.6
	7 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал	4 380	303.5	4 375	358.9
Улсын төсвөөс	1 Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	2 427	476.6	2 383	468.5
	2 Алдар эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	4 895	693.5	4 961	695.2
	3 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж	12	15.7	11	15.8
	4 Насны хишиг	-	-	4 270	366.4
	ДҮН	19 596	3 821.9	23 118	4 560.4

**I.3 БОЛОВСРОЛ****I.3.1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАГЦАГЧДЫН ТОО /сумдаар/**

Сум	Сургуулийн ангилал	Нийт дүн					1-5-р анги			6-9-р анги		10-12-р анги			Үндсэн багшийн тоо	1 багшид ногдох сурагчийн тоо	Дотуур байранд амьдардаг сурагч
		Бүлэг	Бүх сурагчид	Үүнээс: эмэгтэй	Эмэгтэй хүүхдийн эзлэх	Нэг бүлэгт ногдох сурагч	Бүх суралцагчид	Бүгдээс: эмэгтэй	Үүнээс: 1-р ангид	Бүх суралцагчид	Бүгдээс: эмэгтэй	Бүх суралцагчид	Бүгдээс: эмэгтэй	Үүнээс: 12-р ангид			
Ас	дунд	10	238	113	48.5	25.2	150	66	23	88	47	-	-	-	14	17.0	48
Бд	ахлах	33	947	465	50.2	28.3	497	230	127	306	154	144	81	47	49	19.3	110
Да	дунд	18	454	215	44.5	25.5	268	125	74	186	90	-	-	-	23	19.7	30
Мх	ахлах	32	897	460	51.5	28.4	453	229	124	307	150	137	81	66	46	19.5	84
На	дунд	9	223	111	46.9	23.4	148	75	37	75	36	-	-	-	14	15.9	30
Он	ахлах	26	676	342	50.6	26.2	350	166	99	209	114	117	62	47	36	18.8	40
Сб	дунд	18	406	174	43.6	22.9	263	113	82	143	61	-	-	-	25	16.2	60
Тш	дунд	19	485	231	47.4	26.9	307	140	74	178	91	-	-	-	27	18.0	73
Тц	ахлах	21	485	252	52.3	25.2	241	120	57	162	87	82	45	38	30	16.2	45
Уб	дунд	16	392	187	46.0	25.6	263	130	66	129	57	-	-	-	23	17.0	24
Ха	дунд	9	162	86	50.3	18.4	111	60	31	51	26	-	-	-	14	11.6	28
Эц	ахлах	40	1 269	657	52	33	641	349	148	439	193	189	115	92	53	23.9	75
I БДС	ахлах	50	1 703	850	49	34	805	399	182	516	240	382	211	162	74	23.0	114
II БДС	ахлах	33	995	510	54	30	581	286	124	235	123	179	101	79	49	20.3	44
III БДС	ахлах	25	769	396	51	31	357	186	99	276	138	136	72	57	38	20.2	47
IV БДС	ахлах	36	1 183	613	51	34	599	290	137	299	146	285	177	125	52	22.8	107
Дүн		395	11 284	5 662	789	438	6 034	2 964	1 484	3 599	1 753	1 651	945	713	567	19.9	959
2016		370	10 764	5 395	50	29	5 474	2 675	1 233	3 568	1 734	1 722	986	690	549	19.6	970
2015		371	10 471	5 248	50	28	5 142	2 487	1 266	3 221	1 574	2 108	1 187	676	535	19.6	980
2014		366	10 034	4 995	50	27	4 753	2 291	1 067	3 369	1 660	1 912	1 044	520	523	19.2	921
2013		355	9 801	4 855	50	28	4 729	2 267	1 022	3 392	1 672	1 680	916	456	514	19.1	924
2012		354	9 964	4 934	50	28	5 081	2 436	917	3 197	1 553	1 686	945	676	510	19.5	1033



I.3.2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 1, 12-Р АНГИД СУРАЛЦАГЧИД

Сум	1-р ангид				12-р ангид			
	2016-2017		2017-2018		2016-2017		2017-2018	
	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
Ас	38	20	23	10	-	-	-	-
Бд	104	51	127	50	56	30	47	27
Да	62	25	74	42	-	-	-	-
Мх	78	40	124	57	54	30	66	39
На	30	12	37	23	-	-	-	-
Он	78	37	99	49	50	25	47	31
Сб	57	25	82	39	-	-	-	-
Тш	60	24	74	33	-	-	-	-
Тц	46	25	57	25	44	21	38	23
Уб	44	22	66	35	-	-	-	-
Ха	17	9	31	19	-	-	-	-
Эц	127	67	148	79	92	54	92	55
I БДС	174	86	182	89	143	84	162	87
II БДС	130	65	124	50	80	50	79	44
III БДС	70	40	99	52	60	40	57	32
IV БДС	137	64	137	70	111	61	125	83
ДҮН	1 252	612	1 484	722	690	395	713	421

I.3.4. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД АЖИЛЛАГСАДЫН ТОО, сумдаар

Сургуулиуд	Нийт ажиллагсад			Үндсэн багш			Сургалтын менежер			Нийт ажиллагсдын дотор үндсэн багшийн эзлэх хувь	
	2016	2017-2018		2016	2017-2018		2016	2017-2018		2016-2017	2017-2018
		Бүгд	эм		Бүгд	эм		Бүгд	эм		
Ас	25	34	22	14	14	12	1	1	1	56.0	41.2
Бд	92	92	72	47	49	43	3	3	2	51.1	53.3
Да	46	46	32	23	23	17	2	2	2	50.0	50.0
Мх	78	82	58	41	46	39	2	3	3	52.6	56.1
На	36	34	23	15	14	11	1	1	1	41.7	41.2
Он	64	65	49	35	36	30	2	2	1	54.7	55.4
Сү	47	46	37	24	25	20	1	1	1	51.1	54.3
Тш	58	60	48	25	27	20	2	2	2	43.1	45.0
Тц	50	55	39	29	30	22	2	2	2	58.0	54.5
Уб	46	47	31	22	23	17	1	1	1	47.8	48.9
Ха	32	31	25	13	14	11	1	1	1	40.6	45.2
Эц	91	90	73	52	53	45	3	3	3	57.1	58.9
I БДС	112	112	78	75	74	54	4	4	4	67.0	66.1
II БДС	74	78	57	48	49	41	2	2	1	64.9	62.8
III БДС	59	60	44	36	38	29	2	2	2	61.0	63.3
IV БДС	78	80	60	50	52	39	3	3	2	64.1	65.0
дүн	988	1012	748	549	567	450	32	33	29	55.6	56.0



I.3.5.СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН МЭДЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сумдын цэцэрлэг	Бүлгийн тоо		Байрны хүчин чадал, хүүхэд		2016-2017			2017-2018		
	2016-2017	2017-2018	2016-2017	2017-2018	Хамрагдвал зохиx	Хамрагдсан хүүхэд		Хамрагдвал зохиx	Хамрагдсан хүүхэд	
						Бүх хүүхэд	үүнээс: эмэгтэй		Бүх хүүхэд	үүнээс: эмэгтэй
Асгат	5	6	100	100	136	125	65	155	144	75
Баяндэлгэр	12	13	175	175	418	350	168	455	400	196
Дарьганга	7	7	100	100	260	200	105	257	210	107
Мөнххаан	11	12	200	200	446	290	141	429	355	173
Наран	4	5	75	75	131	105	62	150	125	71
Онгон	11	11	200	200	340	330	143	343	331	153
Сүхбаатар	9	8	125	150	288	280	138	304	280	141
Түвшинширээ	8	9	100	100	322	257	122	334	296	156
Түмэнцогт	7	8	145	150	196	189	97	241	205	112
Уулбаян	8	7	100	100	234	200	99	244	195	96
Халзан	5	5	75	75	151	145	75	161	140	70
Эрдэнэцагаан-1	9	9	175	125	325	270	128	360	266	121
Эрдэнэцагаан-2	8	8	120	120	265	215	114	300	230	125
1-р цэцэрлэг	4	4	100	100	263	136	67	163	136	71
2-р цэцэрлэг	7	9	150	150	482	241	114	256	287	133
3-р цэцэрлэг	7	9	150	150	557	236	108	256	285	142
4-р цэцэрлэг	6	5	100	100	162	177	94	188	162	84
5-р цэцэрлэг	4	4	100	100	237	128	60	155	128	61
6-р цэцэрлэг	4	4	100	100	136	121	60	163	135	68
7-р цэцэрлэг	4	4	100	100	179	128	61	147	120	62
8-р цэцэрлэг	7	9	150	150	234	234	112	257	298	137
9-р цэцэрлэг	7	9	175	175	238	242	129	265	296	137
10-р цэцэрлэг	5	5	125	125	166	166	81	196	170	82
11-р цэцэрлэг	-	5	-	150	...	...	...	150	150	76
Дүн	159	175	2 940	3 070	6 166	4 765	2 343	5 929	5 344	2 649



I.3.6. Сургуулийн өмнөх боловсролын ажиллагдсын тоо

Сумдын цэцэрлэг	Нийт ажиллагсад			Үндсэн багш			Туслах багш			Нийт ажиллагсдын	
	2016-2017	2017-2018		2016-2017	2017-2018		2016-2017	2017-2018		2016-2017	2017-2018
		Бүгд	эм		Бүгд	эм		Бүгд	эм		
Асгат	17	17	14	4	4	4	4	4	4	23.5	23.5
Баяндэлгэр	31	32	25	9	10	9	9	9	8	29.0	31.3
Дарьганга	22	22	17	7	7	6	6	6	6	31.8	31.8
Мөнххаан	39	38	30	12	12	12	10	10	8	30.8	31.6
